28

# ДУНДГОВЬ АЙМГИЙН
# ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
# ТОГТООЛ

2019 оны 06 сарын 29 өдөр Дугаар 57 Мандалговь

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Эрдэнэдалай сумын Биеийн тамир спортын төв нь Аймгийн Биеийн тамир, спортын газарт нэгдэн шууд удирдлагатай болж байгаатай холбогдуулан тус байгууллагад ашиглагдаж байсан 34 нэр төрлийн 146,427,469 /нэг зуун дөчин зургаан сая дөрвөн зуун хорин долоон мянга дөрвөн зуун жаран ес/ төгрөгийн балансын үнэтэй, 2,884,224 /хоёр сая найман зуун наян дөрвөн мянга хоёр зуун хорин дөрөв/ төгрөгийн элэгдэл бүхий үндсэн хөрөнгө, 43 нэр төрлийн 4,930,829 /дөрвөн сая есөн зуун гучин мянга найман зуун хорин ес/ төгрөгийн балансын үнэтэй эргэлтийн хөрөнгийг цогцолбороор нь хавсралтын дагуу аймгийн Биеийн тамир, спортын газарт шилжүүлсүгэй.

2. Эрдэнэдалай сумын Засаг дарга С.Мөнхбаатар, Биеийн тамир, спортын газрын дарга М.Наранбадрах нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай. Үүнд:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллага болон сумын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 07-р сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга /О.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

ДАРГА С.СҮХБААТАР

430219133

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2019 оны 6.. сарын 19-ний өдрийн
57 дугаар тогтоолын хавсралт

## БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН МЭДЭЭЛЭЛ

| № | Хөрөнгийн нэр | Ашиглалтанд орсон огноо | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн үнэ | Балансын үнэ | Хуримтлагдсан элэгдэл | Үлдэгдэл өртөг |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Барилга байгууламж** | | | | | | | | |
| 1 | Заалны барилга | 2007.10.01 | м2 | 1 | 132,663,169 | 132,663,169 | - | 132,663,169.25 |
| 2 | Газар | 2018.12.12 | м2 | 544 | 2,000 | 1,088,000 | - | 1,088,000.00 |
| **ДҮН** | | | | | | **133,751,169.25** | **-** | **133,751,169.25** |
| **Машин тоног төхөөрөмж** | | | | | | | | |
| 1 | Гүйлтийн зам | 2016.12.17 | ш | 1 | 1,900,000 | 1,900,000 | 760,000.10 | 1,139,999.90 |
| 2 | Нөутбүүк Dell | 2018.12.25 | ш | 1 | 1,440,000 | 1,440,000 | | 1,440,000.00 |
| 3 | 3 үйлдэлт принтер Samsung 2070 | 2018.12.25 | ш | 1 | 350,000 | 350,000 | | 350,000.00 |
| 4 | Өндөр жин хэмжигч | 2018.12.25 | ш | 1 | 544,500 | 544,500 | | 544,500.00 |
| **ДҮН** | | | | | | **4,234,500.00** | **760,000.10** | **3,474,499.90** |
| **Тавилга, эд хогшил** | | | | | | | | |
| 1 | Сандал | 2013.11.09 | ш | 1 | 41,800.00 | 41,800 | 26,995.90 | 14,804.10 |
| 2 | Дрож | 2018.06.30 | ш | 7 | 100,000.00 | 700,000 | 350,000.00 | 350,000.00 |
| 3 | Резин шал | 2018.06.30 | ш | 15 | 110,000.00 | 1,650,000 | 165,000.00 | 1,485,000.00 |
| 4 | Гарын булчингийн төхөөрөмж | 2018.06.30 | ш | 1 | 235,000.00 | 235,000 | 58,750.00 | 176,250.00 |
| 5 | ком штанг | 2018.06.30 | ш | 1 | 150,000.00 | 150,000 | 60,978.10 | 89,021.90 |
| 6 | мөрний төхөөрөмж | 2018.06.30 | ш | 1 | 250,000.00 | 250,000 | 62,500.00 | 187,500.00 |
| 7 | Хэвлийн дасгалын төхөөрөмж | 2018.06.30 | ш | 1 | 150,000.00 | 150,000 | 37,500.00 | 112,500.00 |
| 8 | Цээжний төхөөрөмж | 2018.06.30 | ш | 1 | 250,000.00 | 250,000 | 62,500.00 | 187,500.00 |
| 9 | 98H22B сандал | 2018.12.31 | ш | 3 | 10,000.00 | 30,000 | | 30,000.00 |
| 10 | Y9898H тавцан | 2018.12.31 | ш | 2 | 25,000.00 | 50,000 | | 50,000.00 |
| 11 | Бөхийн дэвжээ | 2018.12.31 | ш | 1 | 250,000.00 | 250,000 | | 250,000.00 |
| 12 | ВЕ өлгөдөг тумбочка | 2018.12.31 | ш | 1 | 30,000.00 | 30,000 | | 30,000.00 |
| 13 | ВЕ онгорхой шүүгээ | 2018.12.31 | ш | 1 | 30,000.00 | 30,000 | | 30,000.00 |
| 14 | ВЕ татдаг хаалгатай шүүгээ | 2018.12.31 | ш | 1 | 40,000.00 | 40,000 | | 40,000.00 |
| 15 | ВЕ 140 ширээ | 2018.12.31 | ш | 1 | 70,000.00 | 70,000 | | 70,000.00 |
| 16 | Компьютерийн ширээ | 2018.12.31 | ш | 1 | 25,000.00 | 25,000 | | 25,000.00 |
| 17 | Дрож | 2018.12.31 | ш | 1 | 25,000.00 | 25,000 | | 25,000.00 |
| 18 | Сагсны шийд | 2018.12.31 | ш | 1 | 200,000.00 | 200,000 | | 200,000.00 |
| 19 | Урт сандал | 2018.12.31 | ш | 24 | 10,000.00 | 240,000 | | 240,000.00 |

29

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 20 | Хивс | 2018.12.31 | ш | 1 | [illegible]000.00 | 30,000 | | 30,000.00 |
| 21 | Шүүгчийн сандал | 2018.12.31 | ш | 1 | 40,000.00 | 40,000 | | 40,000.00 |
| 22 | Хурлын ширээ | 2018.12.31 | ш | 1 | 40,000.00 | 40,000 | | 40,000.00 |
| 23 | Теннисний ширээ | 2018.12.31 | ш | 2 | 30,000.00 | 60,000 | | 60,000.00 |
| 24 | Суурин дугуй | 2018.12.25 | ш | 1 | 605,000.00 | 605,000 | | 605,000.00 |
| 25 | Штангны гол | 2016.12.17 | ш | 2 | 100,000.00 | 200,000 | 79,999.90 | 120,000.10 |
| 26 | Суултын тавиур | 2016.12.17 | ш | 1 | 650,000.00 | 650,000 | 259,999.90 | 390,000.10 |
| 27 | Налуу шахалтын вандан | 2016.12.17 | ш | 1 | 550,000.00 | 550,000 | 220,000.10 | 329,999.90 |
| 28 | Штангны диск 2.5-25кг 24ш | 2016.12.17 | багц | 1 | 850,000.00 | 850,000 | 340,000.10 | 509,999.90 |
| 29 | Гантель 10-50кг 1ком 17хос | 2016.12.17 | багц | 1 | 1,000,000.00 | 1,000,000 | 400,000.10 | 599,999.90 |
| | ДҮН | | | 77 | | **8,441,800.00** | **2,124,224.10** | **6,317,575.90** |
| **34** | **НИЙТ** | | | | | **146,427,469.25 /нэг зуун дөчин зургаан сая дөрвөн зуун хорин долоон мянга дөрвөн зуун жаран есөн төгрөг хорин таван мөнгө/** | **2,884,224.20 /хоёр сая найман зуун наян дөрвөн мянга хоёр зуун хорин дөрвөн төгрөг хорин мөнгө/** | **143,543,245.05 /нэг зуун дөчин гурван сая таван зуун дөчин гурван мянга хоёр зуун дөчин таван төгрөг таван мөнгө/** |